



XI/2022


Тархаасан: 2022 оны 12 дугаар сарын 14



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.1 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 14.5 хувь, өмнөх оны эцсээс 12.1 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.8 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 24.5 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 19.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 21.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 7.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 12.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 17.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 14.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2022 оны 11 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2022 XI	2022 XI	2022 XI
		2021 XI	2021 XII	2022 X
Ерөнхий индекс	100.0	114.5	112.1	101.1
Хүнсний бараа, ундаа, ус	25.1	116.8	113.3	102.0
Согтууруулах ундаа, тамхи	1.2	108.0	107.5	100.8
Хувцас, бөс бараа, гутал	12.3	119.4	117.1	101.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.3	116.6	114.8	100.4
Гэр ахуйн тавилга, бараа	5.4	116.5	114.2	101.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3	121.4	117.9	100.9
Тээвэр	16.3	107.7	105.9	100.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	5.9	102.2	102.1	100.3
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.9	110.0	109.2	100.8
Боловсролын үйлчилгээ	5.2	106.7	106.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.9	119.2	114.6	100.7
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.5	103.7	103.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.7	121.5	117.9	101.9

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард 11.0 хувь гарсан бол 2022 оны 11 дугаар сард 14.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 2. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 11 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2021 XI	2022 XI	Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 14.5 хувь гарсны 4.5 (30.7%) нэгж хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.
Ерөнхий индекс	11.0	14.5	
Хүнсний бараа, ундаа, ус	4.8	4.5	
Согтууруулах ундаа, тамхи	0.1	0.1	
Хувцас, бөс бараа, гутал	0.5	2.3	
Орон сууц, ус, цахилгаан, түлш	0.3	1.6	
Гэр ахуйн тавилга, бараа	0.4	0.9	
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.5	1.5	
Тээвэр	3.5	1.4	
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.1	0.1	
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.1	0.2	
Боловсролын үйлчилгээ	0.2	0.3	
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.3	0.6	
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.0	0.0	
Бусад бараа, үйлчилгээ	0.4	1.2	


ХҮСНЭГТ 3. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, жил бүрийн 11 дүгээр сард, нэгж хувиар

Үзүүлэлт	2021 XI		2022 XI	
	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь
Ерөнхий индекс	11.0	100.0	14.5	100.0
Импортын барааны нөлөө	6.3	57.3	7.4	51.1

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 404 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээний 221 нь импортын бараа байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 46.0 хувийг эзэлж байна.

Инфляц 2022 оны 11 дүгээр сард 14.5 нэгж хувь гарсны 7.4 (51.1%) нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

ЗУРАГ 2. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 11 дүгээр сард 18.6 хувиар, 2022 оны 11 дүгээр сард 16.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 2.2 нэгж хувиар буурч, харин хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 11 дүгээр сард 8.4 хувиар, 2022 оны 11 дүгээр сард 13.8 хувиар өсөж, өсөлтийн хурдац 5.4 нэгж хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 11 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), бүлгээр, хувь

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2021 XI	Ерөнхий индекс	111.0	109.9	112.9	111.7	114.2	111.5
	Хүнс	118.6	119.5	117.1	117.1	118.6	115.9
	Хүнсний бус	108.4	106.8	111.4	109.7	112.3	109.7
2022 XI	Ерөнхий индекс	114.5	114.5	113.9	114.8	114.6	114.9
	Хүнс	116.4	115.2	116.6	121.7	115.3	118.8
	Хүнсний бус	113.8	114.3	112.8	112.1	114.3	113.2

Хүнсний бүлгийн үнэ 2022 оны 11 дүгээр сард Хангайн бүсэд өмнөх оны мөн үеэс 21.7 хувь, хүнсний бус бүлгийн үнэ Улаанбаатар хот болон Төвийн бүсэд 14.3 хувиар тус тус өссөн нь хамгийн их байна.

ЗУРАГ 3. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 11 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувиар




Барааны бүлгийн үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар, 2022 оны 11 дүгээр сард 16.5 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.3 нэгж хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 11 дүгээр сард 4.8 хувиар, 2022 оны 11 дүгээр сард 8.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.9 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 11 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, бүсээр

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2021 XI	Ерөнхий индекс	111.0	109.9	112.9	111.7	114.2	111.5
	Бараа	113.2	112.1	114.9	113.7	116.9	113.7
	Үйлчилгээ	104.8	104.6	105.9	105.1	105.6	103.8
2022 XI	Ерөнхий индекс	114.5	114.5	113.9	114.8	114.6	114.9
	Бараа	116.5	116.2	115.8	117.3	117.3	116.9
	Үйлчилгээ	108.7	110.1	106.6	105.5	105.4	107.2

Төвийн болон Хангайн бүсэд барааны бүлгийн үнэ 2022 оны 11 дүгээр сард 17.3 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 10.1 хувиар тус тус өссөн нь хамгийн их байна.

ЗУРАГ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх сараас 2.0 хувиар буурахад хонь, ямааны махны үнэ дунджаар 3.5 хувь, үхрийн махны үнэ 1.4 хувь, адууны махны үнэ 1.8 хувиар, харин өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурахад хонь, ямааны махны үнэ 8.9 хувь, адууны махны үнэ 5.9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2022 оны 11 дүгээр сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны эцсээс 11.9 хувь, өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 15.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 8.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 22.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 23.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 30.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 3.8 хувь, боловсролын бүлгийн үнэ 10.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 17.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 11.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 11.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 7.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 20.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 20.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 24.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 1.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 1.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.5 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС сараар (өмнөх оны мөн үеэс), хувиар




Улаанбаатар хотод 2022 оны 11 дүгээр сард хэрэглээний сагсны 404 нэрийн бараа, үйлчилгээнээс 173 (42.8%) нь үнэ өмнөх сараас өсөж, 19 (4.7%) нь үнэ буурч, 212 (52.5%) нь үнэ өөрчлөлтгүй байна.

ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2022 оны 11 дүгээр сард 15390 төгрөг болж, 2020 оны 11 дүгээр сараас 18.8 хувь, 2021 оны 11 дүгээр сараас 2.7 хувиар өсөж, өмнөх сараас 250 (1.6%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 11 дүгээр сард 13226 төгрөг болж, 2020 оны 11 дүгээр сараас 19.4 хувиар өсөж, 2021 оны 11 дүгээр сараас 0.9 хувиар буурч, өмнөх сараас 336 (2.5%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 11 дүгээр сард 9806 төгрөг болж, 2020 оны 11 дүгээр сараас 13.6 хувиар өсөж, 2021 оны 11 дүгээр сараас 9.0 хувиар буурч, өмнөх сараас 432 (4.2%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2022 оны 11 дүгээр сард 2390 төгрөг болж, 2020 оны 11 дүгээр сараас 66.9 хувь, 2021 оны 11 дүгээр сараас 11.1 хувиар өссөн байна.

Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард бүх аймагт өмнөх оны мөн үеэс 11.4-16.5 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард Баян-Өлгий аймагт 11.4 хувиар өссөн нь хамгийн бага, Төв аймагт 16.5 хувиар өссөн нь хамгийн их байна.


ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2022 оны 11 дүгээр сард (өмнөх оны мөн үеэс), хувь, аймаг, нийслэлээр



Аймгуудад худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 11 дүгээр сард 8404 төгрөг болж, 2021 оны 11 дүгээр сараас 781 төгрөгөөр буурсан байна.

Хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 11 дүгээр сард Дундговь болон Говьсүмбэр аймагт 7000 төгрөг байгаа нь хамгийн бага, Баян-Өлгий аймагт 9498 төгрөг байгаа нь хамгийн их байна.

ЗУРАГ 11. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 11 дүгээр сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_{it} – i барааны тайлант үеийн үнэ

P_{io} – i барааны суурь үеийн үнэ

Q_{io} – i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 404 бараа, үйлчилгээ (аймагт 313 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018, 2019, 2020 оны дундаж үр дүнгээр жинг тооцон, 2020 оны шинэчилсэн суурьтайгаар 2022 оны 8 дугаар сараас эхлэн тархааж байна.

Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.



Эх үүсвэр:

ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Ангилал, код:

Хувийн зориулалттай бараа, үйлчилгээний ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 01 дүгээр сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Ц. Тэгшжаргал
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Батсүх, Х.Хонгорзул
Утас : (976-51)-261559

